



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ᠮᠣᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰ
ᠤᠨᠳᠡᠰᠨᠢ
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢ
ᠬᠣᠷᠤᠨ
ᠲᠤᠷᠬᠠᠯᠲ

КОВИД-19

ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАЛДВАРЫН ТАРХАЛТ



2021 оны 6 сарын
20-ны байдлаар



КОВИД-19-ИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД:

КОВИД-19 халдварын нийт батлагдсан тохиолдлыг сүүлийн 3 сарын байдлаар харахад 41.4 хувь нь 5 дугаар сараас өмнө, 25.2 хувь нь 5 дугаар сард, 33.5 хувь нь 6 дугаар сарын 1-20-ны хооронд илэрсэн байна. Харин 0-17 насны хүүхдийн өвчлөл 5 дугаар сард хамгийн өндөр 26.4 хувь, насанд хүрэгчдийн өвчлөлийн дүнд эзлэх хувь 5 дугаар сараас өмнө 78.9 хувь хүрч хамгийн их байжээ.



Улсын хэмжээнд 100 мянган хүн амд ногдох өвчлөлийн түвшин 5 дугаар сараас өмнө 1095 байсан бол 5 дугаар сард 666 болж, 1.6 дахин буурсан байна. Харин 6 дугаар сарын 1-20-ны өдрийн хооронд өвчлөлийн түвшин өмнөх сараас 220-оор нэмэгджээ. 0-17 насны хүүхдийн өвчлөлийн түвшин 6 дугаар сарын 1-20-ны өдрийн хооронд 602 болж, өмнөх сараас 117-гоор нэмэгдсэн байна. 18-аас дээш насны хүн амын өвчлөлийн түвшин 6 дугаар сарын 1-20-ны өдрийн хооронд 1048 болж, өмнөх сараас 278-аар нэмэгджээ.

БАЙРШИЛ:

Улсын дунджаар 2021 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 100 мянган хүн амд ногдох КОВИД-19 халдварын түвшин 2897 байна. Улаанбаатар хотын 100 мянган хүн амд ногдох халдварын түвшин 4512 байгаа нь улсын дунджаас 1.6 дахин их байна. Харин энэ үзүүлэлтийг аймгаар үзвэл, Төв аймагт хамгийн өндөр 2746 бол хамгийн бага нь Баян-Өлгий аймагт 339 байна.



НАСНЫ БҮЛЭГ:

КОВИД-19 цар тахлын батлагдсан тохиолдлыг насны бүлгээр үзэхэд, 20-44 насныхан нийт хүн амын 38.0 хувь, батлагдсан тохиолдлын ихэнх буюу 49.1 хувь байна. Харин тухайн насны 100 мянган хүн амд ногдох өвчлөлийн түвшин 20-44 насанд дунджаар 3391 байгаа нь хамгийн их дараа нь 80-аас дээш насныхны өвчлөлийн түвшин дунджаар 3336 байгаа нь бусад насны бүлгээс өндөр байна.



БОЛОВСРОЛ:

КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлыг хүн амын боловсролын түвшнээр авч үзэхэд, бакалаврын болон дипломын дээд боловсролтой хүн ам илүү өвчилж байна. Тухайлбал, Монгол Улсын нийт хүн амын 21.7 хувь нь бакалаврын болон дипломын дээд боловсролтой, КОВИД-19-ийн батлагдсан нийт тохиолдлын 34.8 хувь нь бакалаврын болон дипломын дээд боловсролтой байна. Бүрэн дунд боловсролтой хүмүүс нийт хүн амын 26.1 хувийг, харин батлагдсан тохиолдлын 29.2 хувийг эзэлжээ.



100 мянган хүн амд ногдох өвчлөлийн түвшнийг боловсролын түвшнээр авч үзэхэд, бакалаврын болон дипломын дээд боловсролтой 100 мянган хүн амд ногдох өвчлөлийн түвшин 4679 байгаа нь хамгийн өндөр байна.

НДШ ТӨЛДӨГ АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛААР:



Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2021 оны 3 дугаар сарын мэдээгээр, манай улсын нийт ажиллагчдын 72.1 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт ажиллаж байгаа бөгөөд КОВИД-19 цар тахалд худалдаа, үйлчилгээний салбарын ажиллагчид хамгийн их өртсөн байна.



Тухайлбал, 2021 оны 6 дугаар сарын 20-ны байдлаар худалдаа, үйлчилгээний салбарт ажилладаг 100 мянган хүн тутмын 4444 нь КОВИД-19-өөр өвчилжээ. Харин хөдөө аж ахуй болон үйлдвэр, барилгын салбарт ажилладаг 100 мянган хүн тутмын 4205-4208 нь КОВИД-19 халдвараар өвчилсөн байна.

НДШ ТӨЛДӨГ АЖИЛЛАГЧИД, АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР

КОВИД-19 цар тахалд эмч, эрүүл мэндийн ажилтнууд хамгийн их өртөж байна. Эрүүл мэндийн салбарт ажилладаг 100 мянган хүн тутмын 6665 нь КОВИД-19 халдвараар өвчилжээ. Мөн менежер болон мэргэжилтэн зэрэг ажилтай хүмүүсийн 100 мянган хүн тутмын 5339-5665 нь КОВИД-19-өөр өвчилжээ.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2021 оны 3 дугаар сарын мэдээгээр, нийт ажиллагчдын 16.5 хувь нь менежерийн ажил хийж байна. Харин КОВИД-19 цар тахлаар өвчилсөн хүмүүсийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзэхэд менежерүүд хамгийн их буюу 19.8 хувийг эзэлж байна.

НДШ ТӨЛДӨГ АЖИЛЛАГЧИД, ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮЛГЭЭР:

КОВИД-19 цар тахлын батлагдсан тохиолдлыг цалин хөлсний бүлгээр авч үзэхэд, 2.2-3.2 сая төгрөгийн цалинтай ажиллагчдын батлагдсан тохиолдол бусад бүлгийнхтэй харьцуулахад хамгийн их тархалттай байна.

Тухайлбал, 2021 оны 6 дугаар сарын 20-ны байдлаар 2.2-3.2 сая төгрөгийн цалинтай ажиллагчдын 100 мянган хүн тутмын 5729 нь КОВИД-19-өөр өвчилжээ. Мөн 3.2-4.2 сая төгрөгийн цалинтай ажиллагчдын 100 мянган хүн тутмын 5679 нь КОВИД-19-өөр өвчилсөн байна.

Харин 420 мянган төгрөг хүртэлх цалинтай ажиллагчдын батлагдсан тохиолдол хамгийн бага байна. Тухайлбал, энэ бүлгийн 100 мянган хүн тутмын 2626 нь КОВИД-19-өөр өвчилсөн байна.



КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлыг ажиллагчдын цалин хөлсний бүлгээр авч үзэхэд, өндөр цалин авдаг ажиллагчид КОВИД-19 халдвараар илүү өвчилж байна.

Тодруулбал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2021 оны 3 дугаар сарын тайланд хамрагдсан ажиллагчдын 27.1 хувь нь 420.0 хүртэл мянган төгрөгийн цалин авдаг бол КОВИД-19-ийн батлагдсан нийт тохиолдлын 17.5 хувь нь энэ бүлэгт хамрагдаж байна. Харин 1.1-2.2 сая төгрөгийн цалинтай ажиллагчид нийт ажиллагчдын 21.6 хувийг эзэлж байна. Энэ бүлгийн цалинтай ажиллагчдын 28.2 хувь нь КОВИД-19 халдвараар өвчилжээ.

СУУЦНЫ ТӨРЛӨӨР:

Улсын хэмжээнд 2020 оны эцсийн байдлаар нийт хүн амын 30.0 хувь нь орон сууц болон бие даасан тохилог сууцанд, 68.1 хувь нь гэр болон сууцны тусдаа байшинд, 1.8 хувь нь бусад сууцанд амьдарч байна.

Ковидын батлагдсан тохиолдлыг 2021 оны 6 дугаар сарын 20-ны байдлаар амьдарч буй сууцны төрлөөр авч үзвэл 49.9 хувь нь гэр, сууцны тусдаа байшинд, 48.4 хувь нь орон сууц болон бие даасан тохилог сууцанд байна.



100 000 хүн амд ногдох өвчлөлийг авч үзэхэд КОВИД-19-ийн батлагдсан тохиолдол гэр хороололд бага байгаа бол орон сууц болон нийтийн байранд их байна.